



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022 05 31 № 05/7576
тнай _____ -ны № _____ -т

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА А.ТЛЕЙХАН
ТАНАА

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Эрчим хүчний зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшэн Баатарын Чимэдрэгзэнгийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Б.Чимэдрэгзэн нь аялал жуулчлал, гадаад хэлний сургалт, барилгын материалын худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Мөнхтүвшин хаус” ХХК-ийн захирлаар бүртгэлтэй байх тул Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйл “Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт”, 19 дүгээр зүйл “Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журам”, 20 дугаар зүйл “Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт”-ыг тус тус хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД

